

**ОУИТБС-ын төрөлжсөн 3-р ажлын хэсгийн
хурлын тэмдэглэл**

Огноо: 2015 оны 4 дүгээр сарын 24, 10 цаг

Хурал болсон газар: Сангийн яам, хурлын танхим

Ирц: Ажлын хэсгийн ахлагч Б.Болормаа, гишүүд Г.Зулай, Д.Энхтуяа, П.Болормаа, Эрдэнэцог, Наранцэцэг, Г.Ганбат нарын бүрэлдэхүүнтэй буюу ажлын хэсгийн нийт 11 гишүүнээс 7 хүрэлцэн ирж, 63% ирцтэй хуралдав.

Хурлыг ажлын хэсгийн ахлагч Сангийн яамны НББГ-ын ахлах мэргэжилтэн Б.Болормаа удирдан явуулав. Хурлын ирц болон өмнөх хурлын шийдвэрийн дагуу хийсэн ажлыг Г.Ганбат танилцуулснаар хурал эхлэв.

1. Маягтад оруулах өөрчлөлтийн талаар ажлын хэсгийн гишүүдээс ирсэн санал
2. Компани болон төрийн байгууллагуудаас ОУИТБС-ын тайлангийн талаар авсан судалгааны үр дүн
3. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд аудитын дүгнэлтийн талаар хэрхэн тусгасан зэргийг дэлгэрэнгүй танилцуулав.

Хэлэлцсэн асуудал 1. Маягтад өөрчлөлт оруулах тухай

Ажлын хэсгийн гишүүдээс ирсэн саналуудыг нэг бүрчлэн ярилцаж 11 санал дэмжигдэж, 3 санал дэмжигдээгүй, 4 саналыг холбогдох байгууллагуудаас дахин тодруулахаар болов.

- 7-р маягтын талаар АМГ дахин тодорхой санал өгөх
- Гадаадын мэргэжилтэн ажилчны ажлын байрны төлбөрийг төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг хоёуланд нь төлж байгааг тодруулах
- Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн дүнг төрийн захиргааны байгууллага, орон нутаг хоёуланд нь төлж байгааг тодруулах

- Газрын тосны газарт байршуулдаг 3% ийн барьцаа төлбөрийн талаар Газрын тосны газраас тодруулах

Хэлэлцсэн асуудал 2. *Компани болон төрийн байгууллагуудаас авсан судалгааны үр дүн*

ОҮИТБС-ын 2014 оны тайлан гаргасан 900 гаруй компаний 691 ажилтанд судалгааны асуулт явуулсан бөгөөд 118 хүн судалгаанд оролцож хариу ирүүлсэн. Мөн төрийн 30 байгууллагад судалгааны асуулт явуулж 7 хариулт ирсэн байна. Судалгааны үр дүнг ажлын хэсгийн тайланд хавсаргах болов.

Хэлэлцсэн асуудал 3. *Аудитын нэгтгэлээр гаргах өгөх нэмэлт мэдээллийн жагсаалт гаргах, түүнд тохирсон маягт боловсруулах, аудитын ажлын даалгаварт оруулах*

Улаанбаатар аудит корпораци ХХК-аас өмнөх жилүүдын ОҮИТБСын нэгтгэлийн үеэр төрийн байгууллагууд болон компаниудаас мэдээлэл хүссэн албан бичиг, хавсралт материалуудыг ажлын хэсэгт өгч, боломжтой зарим мэдээллийн минимум жагсаалтыг гаргахаар болов.

Хэлэлцсэн асуудал 4. *Төрийн байгууллагын болон Компаниудын тайланг аудитаар баталгаажуулах*

Компаниудын тайланг аудитаар баталгаажуулахад гарах хүндрэлийн талаар ажлын хэсгийн гишүүн П.Болормаагийн саналыг танилцуулсан.

Компани бүрийн цар хүрээ, аудиторын хийх ажил харилцан адилгүй байдаг тул компаниудын ОҮИТБС-ын тайланд аудит хийх тариф яг хэд болох талаар тодорхой тоо хэлэх боломжгүй. Томоохон компаниудын хувьд харьцангуй өндөр болох талаар Улаанбаатар Аудит Корпораци ХХК-ын ахлах аудитор Н.Эрдэнэцог тайлбарласан.

Мөн эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийн төсөлд тайланг аудитаар баталгаажуулах талаар хэрхэн тусгасаныг танилцуулж, заавал аудитаар баталгаажуулах шаардлагагүй гэж үзсэн.

Гарсан санал, судалгааны үр дүн, тодруулгын хариунд үндэслэн маягтад оруулах өөрчлөлтийг тусган боловсруулах, ажлын хэсгийн санал зөвлөмжийг төслийг Г.Ганбат бэлтгэж, дараагийн хуралд танилцуулахаар тогтож энэ удаагийн хурал өндөрлөв.

Тэмдэглэл бичсэн: Ажлын хэсгийн нарийн бичиг Г.Ганбат